



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Эрүүл Мэндийн төвийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/55/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7000-3775
Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ЦАГААН-ОВОО СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА. Б.ГАНЧИМЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НЭМ	Нийгмийн эрүүл мэндийн төв

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13

Аудитын тайлан

2.1. Оршил

Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрхлэгч, их эмч Б.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар-т 2020 оны 01 дүгээр сарын 22 -ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын батласан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь Ард иргэдийн хүсэл хэрэгцээг хангахуйц чанартай, аюулгүй тусламж үйлчилгээтэй шилдэг эмнэлэг байна.

Дорнод аймгийн Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг хүн амд хүргэх.

Тайлант хугацаанд байгууллгснхүийн үйл ажиллагаанд мөрдлөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймгийн Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэн байна.

Дорнод аймгийн Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төв санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “AXPLORER” програм хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаад Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төвийн ын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 43 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 431,505,2 төгрөгөөс тооцон 8,630,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8,630,1 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Цагаан -Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 226077,5 мянган төгрөгөөр буюу 44.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	597.9		597.9
Урьдчилгаа			
Бараа материал	1,5316.5	19,654.2	4,337.7
Үндсэн хөрөнгө	494,123.4	716,461.2	222,337.8
Хуримтлагдсан элэгдэл	62,730.2	120,99.5	58,268.3
Нийт хөрөнгө	510,037.8	736,115.4	226,077.6
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	510,037,8	736,115,4	226,077,6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	510,037,8	736,115,4	226077,6

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материалын дансанд 3752,0 мянган төгрөгийн эмнэлэгийн хэрэгсэл орлого болгосон, эмийн үлдэгдэл 1298,9 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байа.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Хөрөнгө оруулалт болон барилгын их засварыг капиталжуулсан, эмнэлэгийн тоног төхөөрөмж худалдан авсан зэрэг 280,6 сая төгрөгийн хөрөнгийг орлого болгосоноор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн яамны болон Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 31,500,0 мянган төгрөгийн автомашин, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эмнэлэгийн барилгын их засвар 130,073.0 мянга, моргийн барилга 76,283.0 мянга, 36,650.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авсан байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Авлагын дансны өмнөх оны 597,9 мянган төгрөгийн үлдэгдэл нь тайлант онд барагдуулсан бөгөөд 2019 онд авлагын данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 226,077,6 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 411,557,6 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 369,208,0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 35,927,1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, 14438,7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 384,256,7 мянган төгрөг буюу 91,6 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 800,0 мянган төгрөгийн Ахмад настны сувилал ажиллуулахад, Хүүхдийн сувилал ажиллуулахад 600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг Аймгийн Эрүүл мэндийн газраас олгосон байна. Орон нутгийн хөрөнгөөр 2500,0 төгрөгийн гадна гэрэлтүүлэгийн ажлын санхүүжилт, 120,0 мянган төгрөгийн өөрийн орлогыг авч зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 43 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 20 эрсдэл тодорхойлж нийт 20 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 23209,3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 9617,6 мянган төгрөгийн залруулга, 140,7 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож 93,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 94,3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 төлбөрийн актыг төлж хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Цагаан-Овоо сумын Эрүүл мэндийн төв 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Нягтлан бодогчоор түр ажиллаж байсан М.Ариунжаргалыг бэлтгэгч гэсэн сул (бэлтгэгчийн ажил хийдэггүй) орон тоонд ажиллуулж няравын ажлыг хавсруулан гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдэл хөлс болох 1155,9 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, залилангийн эрсдэл.

1.3. Шийдвэрлэсэн : Төлбөрийн акт тогтоов

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Сум тосгоны эрүүл мэндийн төвийн MNS:5081-2013 стандартын дагуу ажиллаж байгаа бөгөөд 2016 оны ЭМГ-н 2-39 тоот албан тоот бичгийн чиглэл хүргүүлэх тухай Эрүүл мэнд , спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 498/345 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан сум тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтын аргачлал батлах тухай гэсэн бичиг ирсэн бөгөөд 2016 оны 1 сарын 4-ний өдрөөс эхлэн мөрдлөгө болгосугай гэсний дагуу СДЭ-с бусад ЭМТ-ийг няравын орон тоог бүр хасаж няравгүй болгон төсөвт багтаан ажил хавсран ажиллуул гэсэн чиглэл өгсөн болно.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1 Илрүүлэлт: Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчсөн эсэхийг анхан шатны

баримтаас түүвэрлэн шалгаж, үзэхэд шатахууны зарцуулах нормоос 483,6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

2.3 Өгсөн зөвлөмж: Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар "Жишиг норм батлах тухай" тушаалыг мөрдөж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тушаалыг дагаж мөрдөж ажиллана.

3. **Дотоод хяналт**

3.1. Илрүүлэлт: Тайлант хугацааны сар бүрийн эхэнд тогтмол хэдхэн хүн хувийн хэрэгцээнд гэсэн утга бүхий өргөдөл бичээд 10 сарын турш цалингийн урьдчилгаа авсан бөгөөд хувь хүний цалингаас журманд нийлээгүй албан бус суутгал (үсний найр, хурим, тоглолтын билет, эргэлт, төрсөн өдөр, хандив г.м) хийсэн байна.

3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, байгууллагын дотоод журмыг мөрдөж ажиллаагүй байна.

3.3 Өгсөн зөвлөмж : Байгууллагын дотоод журмыг мөрдөж ажиллах, Хөдөлмөрийн хуулийн дагуу сард 2 удаа цалин тавьж олгож болно.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цалингийн урьдчилгааг дахин олгохгүй бөгөөд хамт олны хурлаар хэлэлцүүлж дотооддоо шийдвэрлэнэ.

4. **Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

4.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээ нөхсөн, ашиглагдахгүй байгаа хэрэглээний 2 программ хангамжыг данс бүртгэлээс хасаагүй байна.

4.2 Эрсдэл: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, УСНББОУС 17 тус тус хэрэгжихгүй байна.

4.3. Өгсөн зөвлөмж: Тус хөрөнгийг журмын дагуу шийдвэр гаргуулж данс бүртгэлээс хасах.

4.2 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

5. **Биет бус хөрөнгийн талаар**

5.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайланд биет бус хөрөнгийн дансанд хяналтын тооллого хийж үзэхэд санхүүгийн программ хангамж бүртгэлгүй байв. Уг программ хангамжыг 2017 онд ашиглаж эхэлсэн бөгөөд данс бүртгэлд тусгаагүй байна

5.2. Эрсдэл: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, УСНББОУС 17 тус тус хэрэгжихгүй байна.

5.3. Өгсөн зөвлөмж: Тус хөрөнгийг журмын дагуу шийдвэр гаргуулж данс бүртгэлээс хасах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

- 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан
- 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

1 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

СТ-1А

4,1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,914,434.5</u>	<u>19,654,188.5</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	15,316,505.5	19,654,188.5
351	Түүхий эд материал	8,697,385.5	13,748,265.5
35110	Тусгай зориулалттай материал	8,697,385.5	12,449,385.5
35130	Эм боох материал	-	1,298,880.0
354	Хангамжийн материал	5,079,120.0	4,365,923.0
35410	Бичиг хэргийн материал	148,500.0	221,720.0
35420	Аж ахуйн материал	1,050,000.0	2,543,613.0
35440	Түлш, шатах тослох материал	2,726,200.0	1,163,430.0
35460	Хүнсний материал	-	124,500.0
35470	Бусад хангамжийн материал	1,154,420.0	312,660.0
35600	Мал амьтад	1,540,000.0	1,540,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>494,123,410.7</u>	<u>716,461,194.9</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	494,123,410.7	716,461,194.9
392	Биет хөрөнгө	484,269,410.7	706,607,194.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	317,150,024.0	523,506,068.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,422,840.5)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,853,434.0	66,353,434.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,411,293.9)	(30,911,293.9)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,356,279.0	182,006,279.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,420,756.5)	(36,170,343.0)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		9,053,640.0	12,653,640.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,039,353.6)	(6,285,590.1)
39214	Бусад үндсэн хөрөнгө	40,123,737.8	42,623,737.8
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,396,300.0)	(39,745,896.3)
393	Биет бус хөрөнгө	9,854,000.0	9,854,000.0
39301	Програм хангамж	462,540.0	462,540.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(462,540.0)	(462,540.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,854,000.0	9,854,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	510,037,845.2	736,115,383.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	510,037,845.2	736,115,383.4
51	Засгийн газрын хувь оролцоо	510,037,845.2	736,115,383.4
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	246,172,369.0	246,172,369.0
		236,318,369.0	236,318,369.0
51101	Өмч: - төрийн	9,854,000.0	9,854,000.0
512	Хуримтлагдсан үр дүн	66,074,582.3	292,152,120.5
51210	Өмнөх үеийн үр дүн	66,074,582.3	66,074,582.3
51220	Тайлант үеийн үр дүн	-	226,077,538.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,790,893.9	197,790,893.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	510,037,845.2	736,115,383.4

СТ-2А

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	425,413,964.0	667,045,296.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,155,064.0	278,768,596.8
120	Нийтлэг татварын бус орлого	112,155,064.0	278,768,596.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	112,155,064.0	269,306,044.0

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	112,155,064.0	269,306,044.0
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		9,462,552.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	313,258,900.0	388,276,700.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	312,224,200.0	369,818,000.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	312,224,200.0	369,818,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,034,700.0	4,020,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	434,700.0	4,020,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	14,438,700.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	14,438,700.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	330,297,726.1	440,967,758.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	330,297,726.1	440,967,758.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,256,866.3	440,967,752.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,663,586.9	241,846,493.0
210101	Үндсэн цалин	160,281,946.3	199,788,274.0
210102	Нэмэгдэл	15,546,563.6	20,850,300.0
210104	Урамшуулал	7,835,077.0	21,207,919.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,252,168.6	31,378,502.0
210201	Тэтгэврийн даатгал	15,172,668.6	21,348,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,026,600.0	2,507,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,295,700.0	2,006,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	341,600.0	501,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,415,600.0	5,014,602.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,448,921.0	11,674,216.0
210301	Гэрэл, цахилгаан	1,840,971.0	2,961,566.0
210302	Түлш, халаалт	12,367,950.0	8,712,650.0
2104	Хангамж, бараа материалын зардал	28,932,093.0	21,215,264.0
210401	Бичиг хэрэг	1,787,020.0	1,748,983.0
210402	Тээвэр, шатахуун	15,014,620.0	14,923,752.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,063,000.0	869,600.0

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	417,100.0	120,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,313,703.0	3,552,929.0
2105	Нормативт зардал	33,815,999.2	43,631,731.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,175,999.2	34,614,687.8
210502	Хоол, хүнс	8,208,000.0	8,731,044.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,432,000.0	286,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,602,900.0	3,762,600.0
210604	Урсгал засвар	2,496,800.0	3,762,600.0
2107	Томилолт, зочны зардал	841,500.0	1,116,200.0
210702	Дотоод албан томилолт	841,500.0	1,116,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,919,845.6	20,588,036.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,706,799.6	20,056,620.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	450,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.0	42,000.0
210807	Газрын төлбөр	62,846.0	39,416.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,779,852.1	65,754,709.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,966,500.0	7,486,450.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,813,352.1	58,268,259.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,859.8	6.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	95,116,238.0	226,077,538.2
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	83,298,149.4	226,077,538.2

3.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	313,258,900.0	388,276,700.0
13.0	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	313,258,900.0	388,276,700.0
1,310.0	Улсын төвлөрсөн төсвөөс	312,224,200.0	369,818,000.0
131,007.0	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	312,224,200.0	369,818,000.0
1,311.0	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,034,700.0	4,020,000.0
131,104.0	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	434,700.0	4,020,000.0
1,320.0	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	14,438,700.0
132,001.0	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	14,438,700.0
2.0	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	313,258,900.0	385,776,700.0
21.0	УРСГАЛ ЗАРДАЛ	313,258,900.0	385,776,700.0
210.0	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,218,040.2	385,776,694.0
2,101.0	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	184,261,515.9	241,248,564.0
210,101.0	Үндсэн цалин	160,879,875.3	199,190,345.0
210,102.0	Нэмэгдэл	15,546,563.6	20,850,300.0
210,104.0	Урамшуулал	7,835,077.0	21,207,919.0
2,102.0	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,978,168.6	31,378,502.0
210,201.0	Тэтгэврийн даатгал	15,172,668.6	21,348,500.0
210,202.0	Тэтгэмжийн даатгал	1,752,600.0	2,507,700.0
210,203.0	ҮОМШӨ-ний даатгал	1,295,700.0	2,006,000.0
210,204.0	Ажилгүйдлийн даатгал	341,600.0	501,700.0
210,205.0	Эрүүл мэндийн даатгал	3,415,600.0	5,014,602.0
2,103.0	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,931,611.0	10,266,446.0

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210,301.0	Гэрэл, цахилгаан	1,840,971.0	2,961,566.0
210,302.0	Түлш, халаалт	4,850,640.0	7,149,880.0
210,303.0	Цэвэр, бохир ус	240,000.0	155,000.0
2,104.0	Хангамж, бараа материалын зардал	25,060,000.0	22,194,637.0
210,401.0	Бичиг хэрэг	1,566,500.0	1,822,203.0
210,402.0	Тээвэр, шатахуун	22,013,400.0	14,081,992.0
210,403.0	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,063,000.0	869,600.0
210,405.0	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	417,100.0	120,000.0
210,406.0	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,300,842.0
2,105.0	Нормативт зардал	33,815,999.2	38,124,812.0
210,501.0	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,175,999.2	26,451,015.0
210,502.0	Хоол, хүнс	8,208,000.0	8,325,797.0
210,503.0	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,432,000.0	3,348,000.0
2,106.0	Эд хогшил, урсгал засварын зардал	9,442,900.0	12,843,300.0
210,601.0	Багаж, техник, хэрэгсэл	5,896,100.0	9,490,000.0
210,604.0	Урсгал засвар	3,546,800.0	3,353,300.0
2,107.0	Томилолт, зочны зардал	841,500.0	1,116,200.0
210,702.0	Дотоод албан томилолт	841,500.0	1,116,200.0
2,108.0	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,919,845.6	20,588,036.0
210,801.0	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,706,799.6	20,056,620.0
210,802.0	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	450,000.0
210,804.0	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.0	42,000.0
210,807.0	Газрын төлбөр	62,846.0	39,416.0
2,109.0	Бараа үйлчилгээний бусад зардал	13,966,500.0	8,016,197.0
210,901.0	Бараа үйлчилгээний бусад зардал	13,966,500.0	8,016,197.0
213.0	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,859.8	6.0
2,133.0	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6.0
	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6.0

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213,303.0			
3.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	2,500,000.0
5.0	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,500,000.0
22.0	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,500,000.0
2,200.0	Дотоод эх үүсвэрээр	-	2,500,000.0
223,001.0	Бусад хөрөнгө	-	2,500,000.0
6.0	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(2,500,000.0)
7.0	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

ТГ

3.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	312,224,200.0	312,183,340.2	419,573,800.0	384,256,700.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,224,200.0	312,183,340.2	419,573,800.0	384,256,700.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,224,200.0	312,183,340.2	419,573,800.0	384,256,700.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	184,261,900.0	184,261,515.9	251,325,400.0	241,248,564.0
210101	Үндсэн цалин	159,127,000.0	160,879,875.3	203,945,100.0	199,190,345.0
210102	Нэмэгдэл	17,842,000.0	15,546,563.6	25,483,700.0	20,850,300.0
210104	Урамшуулал	7,292,900.0	7,835,077.0	21,896,600.0	21,207,919.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,979,700.0	21,978,168.6	31,378,600.0	31,378,502.0
210201	Тэтгэврийн даатгал	15,174,200.0	15,172,668.6	21,348,500.0	21,348,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,752,600.0	1,752,600.0	2,507,700.0	2,507,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,295,700.0	1,295,700.0	2,005,900.0	2,006,000.0
210204	Ажилгүйдлийн	341,600.0	341,600.0		

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	даатгал			501,800.0	501,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,415,600.0	3,415,600.0	5,014,700.0	5,014,602.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,932,400.0	6,931,611.0	14,438,700.0	10,266,446.0
210301	Гэрэл, цахилгаан	1,841,400.0	1,840,971.0	2,700,000.0	2,961,566.0
210302	Түлш, халаалт	4,851,000.0	4,850,640.0	11,538,700.0	7,149,880.0
210303	Цэвэр, бохир ус	240,000.0	240,000.0	200,000.0	155,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	25,030,400.0	25,030,300.0	22,228,300.0	21,959,637.0
210401	Бичиг хэрэг	1,566,500.0	1,566,500.0	2,100,000.0	1,822,203.0
210402	Тээвэр, шатахуун	21,983,800.0	21,983,700.0	14,492,800.0	13,966,992.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,063,000.0	1,063,000.0	935,400.0	869,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	4,520,000.0	5,300,842.0
2105	Нормативт зардал	32,811,900.0	32,810,999.2	38,519,600.0	36,839,812.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,816,000.0	22,815,999.2	26,900,000.0	26,221,015.0
210502	Хоол, хүнс	7,563,000.0	7,563,000.0	7,800,000.0	7,270,797.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,432,900.0	2,432,000.0	3,819,600.0	3,348,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,443,100.0	9,442,900.0	29,391,000.0	12,843,300.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,826,500.0	5,896,100.0	23,160,300.0	9,490,000.0
210604	Урсгал засвар	2,616,600.0	3,546,800.0	6,230,700.0	3,353,300.0
2107	Томилолт, зочны зардал	841,500.0	841,500.0	1,300,000.0	1,116,200.0
210702	Дотоод албан томилолт	841,500.0	841,500.0	1,300,000.0	1,116,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,956,800.0	16,919,845.6	22,976,000.0	20,588,039.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,706,800.0	16,706,799.6	22,276,000.0	20,056,620.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	450,000.0	450,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.0	60,000.0	60,000.0	42,000.0
210807	Газрын төлбөр	70,000.0	62,846.0		

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

				70,000.0	39,416.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	417,100.0	417,100.0	180,100.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.0	70,000.0	70,000.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.0	20,200.0	50,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,966,500.0	13,966,500.0	8,016,200.0	8,016,200.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,966,500.0	13,966,500.0	8,016,200.0	8,016,197.0